



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 21 өдөр

Дугаар A/75.

Улаанбаатар хот

Г 7
Дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтооолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг унагасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Бишрэлт гүн ХХК-ийн "Бишрэлт гүн" зочид буудлын 13/66, Есөн Гарыд ХХК-ийн "Онон" дэн буудлын 13/280 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.
5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 07 сарын 21 өдрийн
A/75 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Бишрэлт гүн ХХК	Бишрэлт гүн	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Их тойруу 68
2	Есөн Гарьд ХХК	Онон	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Өлгийн 31/408

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 07 сарын 21 өдрийн
A/75 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СҮНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Ева Центр ХХК	Ион	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Их тойруу 190

-ооОоо-